

“Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь”-төслийн хүрээнд Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгино-Хайрхан дүүрэг болон Сэлэнгэ, Баянхонгор аймгуудын төрийн өмчийн цэцэрлэгүүд, өрхийн эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дэд бүтцийн засварын ажил гүйцэтгэх компани сонгон шалгаруулах

Японы Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох алсын хараатай, хүүхдэд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах эрхэм зорилготой хүүхдийн төлөөх ажил үйлсээрээ тэргүүлэгч, шашин, улс төрөөс ангид олон улсын бие даасан байгууллага бөгөөд олон улсад 1919 оноос, Монгол улсад 1994 оноос хойш үйл ажиллагаа явуулж, боловсрол, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал болон хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Та бүхэн Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагаа, бидний хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд, манай байгууллагын бодлого журмын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.savethechildren.mn/> хаягаар орж танилцаарай.

ХИС нь 2024 оноос эхлэн Японы Гадаад Харилцааны Яамны Төрийн бүс байгууллагыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээр Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг болон Баянхонгор, Сэлэнгэ аймгуудын төрийн өмчийн 5 цэцэрлэг, 5 өрхийн эмнэлгүүдэд “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь”-ын төслийг хэрэгжүүлж ирсэн.

Энэхүү төсөлд тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан өрхийн эмнэлэг, цэцэрлэгийн орчин, дэд бүтцийг сайжруулах зорилгоор ариун цэврийн өрөө, тэргэнцэртэй хүүхдэд зориулсан налуу зам, шатны зориулалтын бариул хийж тоноглох зэрэг шаардлагатай байгаа юм. Уг засварын ажилд 5 цэцэрлэг, 5 өрхийн эмнэлэгт хийгдэх дараах ажлууд багтсан бөгөөд энэхүү ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх компани сонгон шалгаруулна.

БҮЛЭГ 1. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДӨЛ

№	1. Ерөнхий зүйл			
1	Захиалагч нь: Японы Хүүхдийг Ивээх Сан (ХИС)			
2	Сонгон шалгаруулалтын нэр: “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь”-төслийн хүрээнд Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгино-Хайрхан дүүрэг болон Сэлэнгэ, Баянхонгор аймгуудын төрийн өмчийн цэцэрлэгүүд, өрхийн эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дэд бүтцийн засварын ажил гүйцэтгэх компани сонгон шалгаруулах Сонгон шалгаруулалтын дугаар: SCJT-03/2025. Сонгон шалгаруулалтын багцын талаарх мэдээлэл: <u>Багц 1. Улаанбаатар хот</u>			
	Баянзүрх дүүрэг	320-р цэцэрлэг	Нэмүүлэн өрхийн эмнэлэг	
	Сонгинохайрхан дүүрэг	81-р цэцэрлэг	“Анан” өрхийн эмнэлэг	
	Чингэлтэй дүүрэг	83-р цэцэрлэг	“Мэнд арвижих” өрхийн эмнэлэг	
	<u>Багц 2. Баянхонгор аймаг</u>			
	Баянхонгор аймаг	1-р цэцэрлэг	Оточ манал өрхийн эмнэлэг	
	<u>Багц 3. Сэлэнгэ аймаг</u>			
	Сэлэнгэ аймаг	3-р цэцэрлэг	“Номт Хан” өрхийн эмнэлэг	
	3	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Японы Хүүхдийг Ивээх Сан, Японы Гадаад Хэргийн Яам		
	4	Санал хүлээн авах захиалагчийн хаяг: Японы Хүүхдийг Ивээх сан, Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4-р давхар Лавлах утас: 976-11-329365-131 Сонгон шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор саналын гаднах дугтуйд нэр, ялгах дугаар, багцыг гаргацтай тэмдэглэнэ. Мөн оролцогч нэр хаяг, утсаа тодорхой бичнэ.		
5	Санал хүлээн авах эцсийн хугацаа:			

	Огноо: 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Цаг: 17 цаг 00 минутаас өмнө битүүмжилсэн хэлбэрээр ирүүлэх
2. ТЕХНИКИЙН САНАЛЫН БИЧИГ БАРИМТ	
1	Албан бичиг: Өгөгдсөн техникийн нөхцөлийг ханган удирдамжийн дагуу барилгын засварын ажлыг гүйцэтгэх, НӨАТ шингэсэн үнэ, оролцох сонирхол илэрхийлсэн албан бичиг. Ажил гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөө
2	Байгууллагын танилцуулга /Хүний нөөцийн мэдээлэл, хүчин чадал, тоног төхөөрөмжийн мэдээлэл/ тусгасан байх
3	Сонгон шалгаруулалтад баталгаа ирүүлэх эсэх: Шаардахгүй.
4	Улсын бүртгэлийн гэрчилгээ: Шаардана. Тусгай зөвшөөрөл: Шаардана /хүчин төгөлдөр байх/
5	Хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт: Шаардана. Сүүлийн 2 жил хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалтыг гэрээ, гэрээ дүгнэсэн акт, тодорхойлолт гэх мэт нотлох баримтын хамт ирүүлнэ. (Маягт 1).
3. САНХҮҮГИЙН САНАЛЫН БАРИМТ БИЧИГ	
1	Санхүүгийн саналын хэл: Монгол
2	Санхүүгийн тайлан: Шаардана. 2024 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан.
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт: Шаардана. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн өдрөөс ажлын 3 хоногийн өмнө авсан байх
5	Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцохгүй
6	Гадаадын этгээд оролцох эсэх: Эрхгүй
7	Хувилбарт үнийн санал ирүүлэхийг зөвшөөрөх эсэх: Зөвшөөрөхгүй
8	Санхүүгийн саналын иж бүрдэл: Санхүүгийн санал (Маягт 2)
9	Санхүүгийн саналын дэлгэрэнгүй: Оролцож буй багцаас сонгож объект тус бүрээр үнийн санал ирүүлэх (Маягт 3)
10	Татвар хураамж: Барилгын засварын ажлыг гүйцэтгэхтэй холбоотой гарах татвар, хураамж, шимтгэлийг санал болгож буй үнэд багтаан ирүүлнэ.
11	Үнийн саналын хүчинтэй байх хугацаа нь: Үнийн саналыг нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
12	Үнийн саналын эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувь: Шаардлагагүй. Сонгон шалгаруулалтад оролцогч материалыг өөрийн биеэр эсвэл бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ. Зөвхөн ЭХ ХУВЬ битүүмжилсэн материалыг хүлээн авна.
2. Үнийн саналын баримт бичиг	
1	Захиалагчаас үнийн саналын баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4-р давхар, Захиргаа худалдан авалтын хэлтэс Утас: 976-11-329365-131 И-мэйл хаяг: mongolia.procurement@savethechildren.org
2	Үнийн санал ирүүлэхийн өмнөх үүлзалт зохион байгуулах эсэх: Үгүй.
4. Үнийн санал ирүүлэх	
1	Үнийн санал хүлээн авах захиалагчийн хаяг: Японы Хүүхдийг Ивээх Сангийн төв оффис, Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Аризона төв, 4-р давхар Лавлах утас: 976-11-329365-131
2	Сонгон шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор үнийн саналын гаднах дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: Сонгон шалгаруулалтын нэр: “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь”-төслийн хүрээнд Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгино-Хайрхан дүүрэг болон Сэлэнгэ, Баянхонгор аймгуудын төрийн өмчийн цэцэрлэгүүд, өрхийн эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дэд бүтцийн засварын ажил гүйцэтгэх компани сонгон шалгаруулах Сонгон шалгаруулалтын дугаар: SCJT-03/2025. Сонгон шалгаруулалтад оролцогч нэр хаяг, утсаа тодорхой гаргацтай бичнэ.

3	Үнийн санал хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <u>2025 оны 05 дугаар сарын 23, Цаг: 17 цаг 00</u> минутаас өмнө битүүмжилсэн хэлбэрээр ирүүлэх
5. Техникийн болон Үнийн саналыг нээх	
Санал ирүүлэх эцсийн хугацаа дууссаны дараа үнэлгээний баг Техникийн санал, Санхүүгийн саналыг нээнэ. Үнэлгээний баг техникийн нөхцөлд заасан шаардлагыг хангаж байгаа байдал, байгууллагын чадамж мөн үнийн санал зэргийн үнэлгээ хийж шалгаруулна.	

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1	Гэрээнд гарын үсэг зурах: Гүйцэтгэгчээр шалгарсан оролцогч нь гэрээ байгуулах тухай мэдэгдсэнээс хойш ажлын 3 өдөрт багтааж гэрээг байгуулна. Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулсан өдөр. Татвар, даатгал хураамж: Гэрээний үнэнд холбогдох татвар хураамж багтсан байх. Захиалагчийн төлөх алдангийн хувь: Хоног тутамд 0.2 хувь. Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Хоног тутамд 0.2 хувь Төлбөрийн нөхцөл: Урьдчилгаа 40 хувь барилгын засварын ажил гүйцэтгэсний дараа 40 хувь, зорилтот цэцэрлэг, өрхийн эмнэлгийн эрх бүхий этгээдүүд ажлыг бүрэн гэж үзсэн нөхцөлд үлдэгдэл 20 хувь төлбөр төлнө. Төлбөр хийх хугацаа: Төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш 5 өдөрт багтаан санхүүжилтийг хийнэ. Гүйцэтгэлийн тайлан: Гүйцэтгэлийн тайлан нь барилгын ажил хийж гүйцэтгэсэн объект тус бүрээр харуулсан байна. Гэрээний үнэ: Гэрээний үнэд тохируулга хийхгүй гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна.
---	---

БҮЛЭГ 2. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ НӨХЦӨЛ

1. Ажлын үндэслэл, хэрэгцээ

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөр нь 2024 оноос эхлэн Японы Гадаад Харилцааны Яамны Төрийн бус байгууллагыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээр Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг болон Баянхонгор, Сэлэнгэ аймгуудын төрийн өмчийн 5 цэцэрлэг, 5 өрхийн эмнэлгүүдэд “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь”-ын төслийг дээр хэрэгжүүлнэ.

Энэхүү төсөлд тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан өрхийн эмнэлэг, цэцэрлэгийн орчин, дэд бүтцийг сайжруулах зорилгоор ариун цэврийн өрөө, тэргэнцэртэй хүүхдэд зориулсан налуу зам, шатны зориулалтын бариул хийж тоноглох зэрэг шаардлагатай байгаа юм. Уг засварын ажилд 5 цэцэрлэг, 5 өрхийн эмнэлэгт хийгдэх дараах ажлууд багтсан болно.

	Байгууллага	Хийгдэх ажил
1.	БЗД-ийн 320 дугаар цэцэрлэг	Налуу зам: 1.Цэцэрлэгийн ар талын хаалганы шатанд налуу замыг туслах бариулын хамт хийлгэх Хаалга (72 см) илүү өргөн байх ба хаалганы босгыг (3.5 см) хасах болно. *ЯХИС-ийн удирдамжийн дагуу орох хаалганы өргөн 90 см байх ёстой. Орох хаалганы босгоны өндөр нь 2 см-ээс багагүй байна. Шат: 2. Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан дэмжих бариулыг (ханан дээр) давхар хоорондын шатны (1-р давхраас 3-р давхар хүртэл). Мөн 1-р давхраас подвалын байрлах хөгжмийн танхим хүртэлх шатны хананд дэмжих бариул суурилуулах Ариун цэврийн өрөө: 3. Цэцэрлэгийн 2, 3 давхрын 4 ангийн 4 ариун цэврийн өрөөнд тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан суултуур, угаалтуурыг туслах бариулын хамт (нэг ангид нэг жорлон, нэг угаалтуур суурилуулах, нийт 4 анги) суурилуулах. 4. Ариун цэврийн өрөөний үүдний хаалганы (75 см, 74 см, 74 см, 72 см) өргөн, үүдний босгыг (4 см, 2 см) шинэчлэн засварлах Коридор: 5. 2 дугаар давхрын хүүхэд хөгжлийн танхимын хажуу талын хананд дэмжих бариул суурилуулах
2.	БЗД-ийн “Нэмүүлэн” өрхийн эмнэлэг	Гадна талын хаалга, налуу зам: 1. ӨЭМТ-ийн гадна шатны налуу замын баруун талын хананд туслах бариул суурилуулах 2. Хаалганы (74см) өргөн, босгыг (15см) стандартын дагуу шинэчлэн засварлах Ариун цэврийн өрөө: 3. 1 дүгээр давхрын ариун цэврийн өрөөний суултуурын туслах бариул тогтворгүй тул шинээр солих 4. Угаалтуурт зориулсан туслах бариул суурилуулах 5. Ариун цэврийн өрөөний хаалганы (55см) өргөн, үүдний босгыг (5см) стандартын дагуу шинэчлэн засварлах.
3.	Баянхонгор аймгийн 1-дүгээр цэцэрлэг	Гол хаалга: 1. Цэцэрлэгийн гол хаалганы гадна талын налуу замыг стандартын шаардлагад нийцүүлэн засварлаж, хоёр талд нь бариул хийх. 2. Орох хаалганы (70см) өргөн, босгыг стандартын дагуу шинэчлэн засварлах Шат: 3. Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан бариулыг 1-2 дугаар давхрын шатны хананд суурилуулах

		Ариун цэврийн өрөө: 4. Цэцэрлэгийн 1 дүгээр давхрын 4 ангийн ариун цэврийн өрөөнд тус бүр 2 суултуур, угаалтуурт туслах бариул суурилуулах 5. Ариун цэврийн өрөөний орох хаалганы (74см) өргөнийг засварлах Коридор: 6. 1-р давхрын коридорын нэг талын хананд бариул суурилуулах
4.	Баянхонгор аймгийн “Оточ манал” өрхийн эмнэлэг	Гол хаалга: 1. Гол хаалганы налуу замыг стандартын дагуу засварлаж туслах бариул суурилуулах 2. Хаалганы (70см) өргөн, үүдний босгыг (8см, 5см) шинэчлэн засварлах
5.	СХД-ийн 81 дүгээр цэцэрлэг	Коридор: 1. 1 ба 2-р давхрын коридорын нэг талын хананд туслах бариул суурилуулах Ариун цэврийн өрөө: 1. Цэцэрлэгийн 1-р давхрын нэг ангийн ариун цэврийн өрөөнд тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан жорлонгийн суултуур, угаалтуур туслах бариулын хамт суурилуулах 2. Ариун цэврийн өрөөний орох хаалганы (83см) өргөн, босгыг (3см) шинэчлэн засварлах Арын хаалга: 3. Цэцэрлэгийн арын хаалганы шатанд налуу зам болон туслах бариул хийлгэх 4. Арын хаалгыг (85см) илүү өргөн, босгыг (8см) стандартын дагуу шинэчлэн засварлах Цэцэрлэгийн хашааны хаалга: 5. Цэцэрлэгийн гадна талын хашааны хаалганы шатанд налуу зам, туслах бариулын хамт хийлгэх 6. Цэцэрлэгийн гол хаалга (79см) болон гадна хашааны хаалганы (84см) өргөн, үүдний босгыг (үндсэн хаалга 14см, гадна хашааны хаалга 35см) шинэчлэн засварлах
6.	СХД-ийн “Анан” өрхийн эмнэлэг	Гол хаалга: 1. Гол хаалганы (85см, 78см) өргөн, босгыг (4см, 6см) стандартын дагуу шинэчлэн засварлах Шат: 2. 1-2-р давхрын шатны хооронд зүүн талын хананд тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан бариул суурилуулах Ариун цэврийн өрөө: 3. 1-р давхрын ариун цэврийн өрөөний суултуур, угаалтуурын бариул тогтворгүй тул солих 4. 1-р давхрын ариун цэврийн өрөөний үүдний хаалганы (70см) өргөн, босгыг (6см) шинэчлэн засварлах
7.	ЧД-ийн “Мэнд арвижих” өрхийн эмнэлэг	Гол хаалга: 1. Орцны хаалганы (77см) өргөн, үүдний босгыг (2.0-2.5см) шинэчлэн засварлах. Коридор: 1) 1, 2-р давхрын хананд тус бүр туслах бариул суурилуулах Шат: 3. 1-2 дугаар давхар хоорондын шатны баруун талын хананд тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан бариул суурилуулах Ариун цэврийн өрөө: 4. Нэгдүгээр давхрын ариун цэврийн өрөөний орох хаалганы (79см) өргөнийг шинэчлэн засварлах Ар талын хаалга: 5. Гадна налуу зам хийж, туслах бариул суурилуулах. 6. Арын хаалгыг (82см) илүү өргөн болгож засварлах

8.	ЧД-ийн 83 дугаар цэцэрлэг	Гадна талын хашааны хаалга: 1. Цэцэрлэгийн гадна хашааны хаалганы шатанд налуу зам, туслах бариулын хамт хийлгэх 2. Цэцэрлэгийн гадна талын хаалганы ойролцоох хашлагыг (5 см өндөртэй тул) намсгаж, жижиг налуу зам суулгаж шинэчлэх Шат: 3. Цэцэрлэгийн 1-р давхраас 2-р давхар хүртэлх давхар хоорондын шатны хананд тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан туслах бариул суурилуулах Коридор: 4.Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан туслах бариулыг 1, 2 давхарт нэг талын хананд суурилуулах Ариун цэврийн өрөө: 5. 1-р давхрын 2 ангийн ариун цэврийн өрөөнд тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан угаалтуур, суултуурыг туслах бариулын хамт суурилуулах. 6. Ариун цэврийн өрөөний хаалганы (Анги 1: 70 см, Анги2: 68,5 см) өргөн, үүдний босгыг (Анги 1-10 см, Анги 2-10 см) стандартын дагуу шинэчлэн засварлах. Цэцэрлэгийн гол хаалга: 7. Цэцэрлэгийн гол хаалганы налуу замыг стандартын засварлаж бариул суурилуулах. 8. Мөн дотор талын хаалганы (70см, 65см) өргөн, үүдний босгыг (2см, 14см) шинэчлэн засварлах.
9.	Сэлэнгэ аймгийн 3 дугаар цэцэрлэг	Гол хаалга: 1. Цэцэрлэгийн гол хаалганы довжоонд налуу зам, туслах бариулын хамт хийлгэх 2. Хаалганы өргөн (80см), үүдний босгыг (7см) шинэчлэн засварлах Баруун талын хаалга: 3. Баруун талын хаалганы шатанд налуу зам, туслах бариулын хамт хийлгэх 4. Баруун талын хаалганы (80см) өргөн, шатыг (16см) стандартын дагуу шинэчлэн засварлах Зүүн талын хаалга: 5. Зүүн талын үүдэнд налуу зам, туслах бариул суурилуулах 6. Зүүн талын хаалганы (80см) өргөн, шатыг (16см) шинэчлэн засварлах Шат: 7. Цэцэрлэгийн 1-2 давхрын шатны баруун талын хананд туслах бариул хийлгэх Ариун цэврийн өрөө: 8. Цэцэрлэгийн 1, 2-р давхрын 2 ангийн ариун цэврийн өрөөнд (тус бүр нэг суултуур, угаалтуур 2 ангид) тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан жорлонгийн суултуур, угаалтуур, туслах бариулын хамт шинээр хийх. 9. Ариун цэврийн өрөөний орох хаалганы (1-р давхар: 71 см, 2-р давхар: 71.5 см) өргөн, босгыг (1 давхар: 9 см, 2 давхар: 3 см) шинэчлэн засварлах Коридор: 9. Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан бариулыг 1, 2 давхарт нэг талын хананд суурилуулах
10.	Сэлэнгэ аймгийн “Номт Хан” өрхийн эмнэлэг	Гол хаалга: 1. Гол хаалганы үүдний шатанд налуу замыг стандартын дагуу засварлаж, туслах бариул хийх Коридор: 2. 1-р давхрын коридорын хананд бариул хийлгэх Ариун цэврийн өрөө: 1. Ариун цэврийн өрөөнд суултуур, бариул шинээр суурилуулах 2. Хаалга бүрэн нээгддэггүй тул угаалгын өрөөний шинэ хаалга суурилуулах; Хоёр дахь хаалганы (67см) өргөнийг шинэчлэн засварлах 3. Тэргэнцэр явах боломжгүй тул дотоод хаалганы налуу зам, бариул шинээр хийх; Эхний хаалганы (60см) өргөн ба босгыг (3см) шинэчлэн засварлах 4. Шинэ угаалтуур, бариулын хамт суурилуулах

2. Засварын ажлын хугацаа

Засварын ажлын нийт хугацаа 30 хоног байна.

Гүйцэтгэх ажил	Хугацаа
Засварын ажлын нөхцөлийн талаар гүйцэтгэгч компанитай тохиролцож, гэрээнд гарын үсэг зурах	Гэрээ хийх мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт
Төслийн зорилтот цэцэрлэг, өрхийн эмнэлгүүдэд дээр очиж засварын ажил хийж гүйцэтгэх	30 өдөр
Захиалагчийн тавьсан шаардлагын дагуу нэмэгдэл ажил гүйцэтгэх, сайжруулах	4 өдөр
Засварын ажлыг хүлээлгэн өгөх	4 өдөр

БҮЛЭГ 3. МАЯГТУУД

МАЯГТ 1

СҮҮЛИЙН 2 ЖИЛ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл/Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас	Гүйцэтгэсэн хугацаа (дууссан, хугацаа)	Гэрээний үнэ (сая.төг)	Хавсаргасан материалын жагсаалт

САНХҮҮГИЙН САНАЛ

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[зөвлөх үйлчилгээний нэр, дугаар]** сонгон шалгаруулалтад **[санхүүгийн үнийн дүнг тоогоор болон үсгээр бичнэ]** төгрөгөөр сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү үнийн санал (цаашид **“үнийн санал”** гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Сонгон шалгаруулалтын бичиг баримттай танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч сонгон шалгаруулалтад оролцсон.
2. Үнийн саналтай холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
3. Үнийн санал нь сонгон шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу үнийн саналыг нээснээс хойш **[30]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
4. Үнийн саналд хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг саналыг илт худал мэдээлэл бүхий санал гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
5. Үнийн саналыг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, үнийн саналыг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэнчөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс

эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:Хаяг:

САНХҮҮГИЙН САНАЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

Багц 1

Объектын нэр	Үнийн санал /төгрөгөөр/
БЗД, 320-р цэцэрлэг	
БЗД, Нэмүүлэн өрхийн эмнэлэг	
СХД, 81-р цэцэрлэг	
СХД, “Анан” өрхийн эмнэлэг	
ЧД, 83-р цэцэрлэг	
ЧД, “Мэнд ариажих” өрхийн эмнэлэг	

Багц 2

Объектын нэр	Үнийн санал /төгрөгөөр/
Баянхонгор аймаг, 1-р цэцэрлэг	
Баянхонгор аймаг, Оточ манал өрхийн эмнэлэг	

Багц 3

Объектын нэр	Үнийн санал /төгрөгөөр/
Сэлэнгэ аймаг, 3-р цэцэрлэг	
Сэлэнгэ аймаг, “Номт Хан” өрхийн эмнэлэг	